


Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

Хөвсгөл ХК

2021 оны 12 дугаар сарын 31



Агуулга

Хараат бус аудиторын дүгнэлт	1
Санхүүгийн байдлын тайлан	4
Орлогын дэлгэрэнгүй тайлан	5
Өмчийн өөрчлөлтийн тайлан	6
Мөнгөн гүйлгээний тайлан	7
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	8

Компанийн талаарх мэдээлэл

Компанийн нэр:	"Хөвсгөл" ХК	
Үүсгэн байгуулах шийдвэр:	Хөвсгөл ХК нь Монгол улсын хуулийн дагуу 2019 оны 4 дүгээр сарын 26-нд Улсын бүртгэлд албан ёсоор бүртгүүлсэн.	
Гэрчилгээ ба лиценз	000153120 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ	
Төлөөлөн удирдах зөвлөл	Дарга	Л. Дашцэрэн
	Гишүүд	Л. Тэгшбаяр
		Д. Ган-Очир
		Л. Цэрэнжав
		Ж. Сайнжаргал
	Л. Тунгалаг	
Удирдлагын баг:	Гүйцэтгэх захирал	Л. Тэгшбаяр
Хаяг:	Хөвсгөл, Мөрөн, 3-р баг, 1-р гудамж	
Регистрийн дугаар:	2034611	
Үйл ажиллагаа:	<ul style="list-style-type: none">- Үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх- Модон эдлэл үйлдвэрлэх засварлах- Гэрийн мод үйлдвэрлэл- Төрөлжсөн бус барааны бөөний худалдаа	
Аудитор:	"Грант Торнтон Аудит" ХХК, Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага	

Хараат бус аудиторын дүгнэлт

Далай таур, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
Т + 976 70 110744
+ 976 70 110799

“Хөвсгөл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид “Хөвсгөл” ХК (цаашид “компани” гэх)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан,
- Орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, “Хөвсгөл” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Онцлох асуудал

2022 оны 2 дугаар сарын 21-ний өдөр компанийн нийт хувьцааны 93.7 хувийг өөр этгээдэд шилжүүлэн өмчлөгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон байна. Компанийн өмчлөл шилжсэнтэй холбоотойгоор төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын багийг хараахан томилоогүй байна.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компаний удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92, 94-р зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Н.Эрдэнэцог болно.



GRANT THORNTON
AUDIT LLC

GRANT THORNTON
УДИРДАХ ПАРТНЕР

2022 оны 04 дугаар сарын 08

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгийн дүн			
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө, цэвэр	5	-	155,098
Эргэлтийн бус хөрөнгийн дүн			
Нийт хөрөнгө			
Өр төлбөрийн нийт дүн			
Эздийн өмч			
Хувьцаат капитал	6	5,196	35,261
Дахин үнэлгээний нэмэгдэл	7	-	119,837
Хуримтлагдсан алдагдал		(5,196)	-
Эздийн өмчийн дүн			
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн			

Уг санхүүгийн байдлын тайланг 2022 оны 4 дүгээр сарын 08-нд батлав.

Хуудас 8-11-д харуулсан тодруулгууд нь энэхүү орлогын дэлгэрэнгүй тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2021 он	2020 он
Ерөнхий ба удирдлагын зардал		-	-
Үйл ажиллагааны алдагдал		-	-
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг		-	-
Татвар төлөхийн өмнөх алдагдал		-	-
Орлогын татварын зардал		-	-
Татварын дараах ашиг алдагдал		-	-
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		-	-
Тайлант үеийн цэвэр алдагдал		-	-
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Орлогын нийт дүн		-	-
Нэгж хувьцаанд ногдох суурь (алдагдал)		-	-

Хуудас 8-11-д харуулсан тодруулгууд нь энэхүү орлогын дэлгэрэнгүй тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Хувьцаат капитал	Эдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан алдагдал	Нийт дүн
2020 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	35,261	119,837	-	155,098
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	35,261	119,837	-	155,098
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	35,261	119,837	-	155,098
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	(30,065)	(119,837)	(5,196)	(155,098)
Залруулсан үлдэгдэл	5,196	-	(5,196)	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	5,196	-	(5,196)	-

Хуудас 8-11-д харуулсан тодруулгууд нь энэхүү өмчийн өөрчлөлтийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Мөнгөн гүйлгээний тайлан

ТОДРУУЛГУУД

Мянган төгрөгөөр	Тодруулга	2021 он	2020 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		-	-
Мөнгөн зарлагын дүн		-	-
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		-	-
Мөнгөн зарлагын дүн		-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-

Хуудас 8-11-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Санхүүгийн тайлангийн тодруулгууд

1. Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

"Хөвсгөл" ХК нь Монгол улсын хуулийн дагуу 2019 оны 4-р сарын 26-нд Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж, 2034611 регистрийн дугаартай, 000153120 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

Үндсэн үйл ажиллагааны чиглэл нь дараах байдалтай байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх
- Модон эдлэл үйлдвэрлэх засварлах
- Гэрийн мод үйлдвэрлэл
- Төрөлжсөн бус барааны бөөний худалдаа

Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,195.6 ширхэг энгийн хувьцаатай. Тодруулга №8-с хувьцаа эзэмшил, хяналтын харилцааны талаарх мэдээллийн дэлгэрэнгүйг харна уу.

Бүртгэгдсэн хаяг: Хөвсгөл, Мөрөн, 3-р баг, 1-р гудамж 25 тоот

2. Ерөнхий мэдээлэл, СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагааны таамаглал

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-д (эсвэл) нийцүүлэн бэлтгэсэн болно.

Эдгээр санхүүгийн тайланг компани нь тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн. 2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангууд түүний тодруулгуудыг 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр байгууллагын удирдлага баталсан.

Тасралтгүй үйл ажиллагаа

НББОУС 1-д заасны дагуу удирдлага нь тайлант хугацаанаас хойш багадаа 12 сарын ирээдүйн хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад эргэлзээ төрүүлэх асуудлууд байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай. Ийнхүү үнэлэхдээ одоогийн болон хүлээгдэж буй ашигт ажиллагаа, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, боломжит санхүүжилтийн эх үүсвэр болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадавхи зэрэг өргөн хүрээний хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

Компани санхүүгийн тайлангаа тасралтгүй үйл ажиллагааны зарчимд үндэслэн бэлтгэсэн бөгөөд энэ нь Компани ойрын ирээдүйд хөрөнгөө бизнестээ хэвээр үлдээж, өр төлбөрөө төлж, үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулна гэдгийг илэрхийлнэ.

Компани нь хөрөнгө байхгүй, анх оруулсан хөрөнгө оруулалт нь алдагдал болсон нь цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй мэт байгаа боловч компанийн ихэнх хувьцааг өөр этгээдэд шилжсэнээр үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөх, шинээр их хэмжээний хөрөнгө оруулалт татсанаар бизнесийн шинэ салбарт үйл ажиллагаагаа тэлэх, шинээр төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын баг томилох зэрэг компанийг цаашид үр дүнтэй үйл ажиллагаа явуулах төлөвлөгөөг боловсруулж байна.

3. Шинэ болон өөрчлөлт орсон стандартууд болон хэрэглээний тайлбарууд

3.1. 2021 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн шинэ стандартууд

2021 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх Бенчмарк хүүгийн түвшний реформ 2 үе шат, СТОУС-4 "Даатгалын гэрээ"-ний нэмэлт өөрчлөлт-СТОУС 9-ийн хэрэгжилтийг хойшлуулах болон 2021 оны 4 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж эхлэх СТОУС 16 "Түрээсийн нэмэлт өөрчлөлт-COVID19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт бөгөөд тэдгээр нь байгууллагын санхүүгийн үр дүн болон байдалд томоохон нөлөө үзүүлэхээргүй байна.

3.2. Хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд

Санхүүгийн тайланг баталсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөх хугацаа болоогүй СТОУС3- "Бизнесийн нэгдэл"-ийн нэмэлт өөрчлөлт-Суурь үзэл баримтлалуудын лавлагаа болон бусад стандарт, стандартын нэмэлт өөрчлөлтүүдийг байгууллага нь урьдчилан мөрдөж эхлээгүй байгаа юм.

Байгууллагын удирдлага тухайн өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр болох өдөр эсвэл түүний дараагаар мөрдөж эхлэхээр төлөвлөж байна. Тайлант онд дагаж мөрдөх шаардлагагүй тухайн өөрчлөлтүүдийг тодруулаагүй ба тэдгээр нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй.

4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

4.1. Бүртгэлийн суурь

Эдгээр санхүүгийн тайланг акрузль сууриар бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, хөрөнгө оруулалт болон тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийг түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

4.2. Гадаад валют хөрвүүлэлт

Үйл ажиллагааны болон толилуулгын валют

Санхүүгийн тайлангууд нь Монгол төгрөгөөр илэрхийлэгддэг.

Гадаад валютаарх ажил гүйлгээ болон үлдэгдэл

Санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монгол банкнаас тайлагналын өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 31-нд төгрөгийн амдоллартай харьцах ханш 2,848.80 байв (2020 оны 12 дугаар сарын 31-нд: 1 ам.доллар 2,849.51 төгрөг)

Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлсэн түүхэн өртгөөр хэмжинэ.

Мөнгөн зүйлсийг дахин хөрвүүлэх болон төлбөр тооцоо хийхэд үүссэн ханшийн зөрүүг тухайн хугацааны ашиг, алдагдалд багтаана. Мөнгөн бус зүйлсийн хөрвүүлгээс үүссэн зөрүүний олз, гарзыг шууд өмчид хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд багтаана. Тийм мөнгөн бус зүйлсийн хувьд олз, гарзын аливаа ханшийн зөрүүний хэсгийг шууд өмчид хүлээн зөвшөөрнө.

4.3. Үндсэн хөрөнгө

Барилга, компьютер дагалдах хэрэглүүр болон бусад тоног төхөөрөмжийг зэрэг хөрөнгийг ашиглалтын байршилд авч ирэхэд гарсан зардлууд болон тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай гарсан зардлуудыг хамруулан худалдан авсан өртөг эсвэл үйлдвэрлэлийн өртгөөр анхлан бүртгэнэ. Санхүүгийн түрээсийн хөрөнгүүдийг барилга болон компьютер дагалдах хэрэглүүрийн адил бүртгэнэ. Ажил үйлчилгээний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн

"Хөвсгөл" ХК
Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

зорилгоор ашиглаж буй зэрэг хөрөнгүүдийг санхүүгийн тайланд дахин үнэлсэн дүн буюу дахин үнэлгээ хийсэн өдрөөрх дүнгээс дараа үеийн хуримтлагдсан элэгдсэн болон дараа үеийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайлагнана.
Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхэлнэ.

5. Үндсэн хөрөнгө

Мянган төгрөгөөр	Барилга, байгууламж	Нийт
<i>Өртөг</i>		
2020 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	155,098	155,098
Нэмэгдсэн	-	-
Хасагдсан	-	-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	155,098	155,098
Нэмэгдсэн	-	-
Хасагдсан	155,098	155,098
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-
<i>Хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралт</i>		
2020 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	-	-
Тухайн жилийн өөрчлөлт	-	-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-
Тухайн жилийн өөрчлөлт	-	-
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-
<i>Үлдэгдэл өртөг</i>		
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	155,098	155,098
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-

Тайлант хугацаанд 155,098 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй гэж санхүүгийн тайланд тусгагдсан боловч бодитоор оршин байхгүй тул данснаас хасаж залруулсан болно.

6. Капитал ба нөөц

6.1. Хувьцаат капитал /дүрмийн сан/

Хувьцааны тоо өөрөөр заагаагүй бол мянган төгрөгөөр	Энгийн хувьцаа	
	2021	2020
Эргэлтэнд буй хувьцааны тоо /ширхгээр/	51,956	N/A
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ /төгрөгөөр/	100	N/A
Хувьцаат капиталын нийт дүн	5,196	35,261

Компани нь тогтмол орлогын эрхгүй энгийн хувьцааны нэг л ангилалтай.

Тайлант хугацаанд компанийн дүрмийн сангаас 30,065 мянган төгрөгөөр илүү илэрхийгдсэн, нотлогдох боломжгүй гэж үзсэн хувийн өмчийн дүнг өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнрүү залруулсан байна.

6.2. Хуримтлагдсан ашиг/алдагдал

Компанийн хуримтлагдсан ашиг, алдагдал нь үйл ажиллагаа эхэлснээс хойш байнга өөрчлөгдөж байдаг капиталын нөөц бөгөөд буюу тухайн тайлангийн хугацаанд олсон цэвэр ашгийн хэмжээгээр нэмэгдэж, алдагдлын дүнгээр буурдаг.

7. Дахин үнэлгээний нэмэгдэл

Мянган төгрөгөөр	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Нийт дүн
2021 оны 1 сарын 1	119,837	119,837
Нэмэгдсэн		
- Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт	-	-
Хасагдсан дүн		
- НББ-ийн залруулга	119,837	119,837
2021 оны 12 сарын 31	-	-

Дээрх үндсэн хөрөнгөнд хамаарах 119,836 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн хуримтлагдсан үр дүнрүү залруулсан байна.

8. Холбоотой талын ажил гүйлгээ

Компанийн холбоотой талд голлох удирдлага, хараат болон хамтын хяналттай компани, толгой болон охин компани, нэгдмэл хяналт дор байдаг зэрэгцээ аж ахуйн нэгжүүд хамаарна.

Компанийн холбоотой талуудад толгой компани, охин компани (тусадаа санхүүгийн тайлантай) хараат компани, хамтын хяналт, удирдлагатай аж ахуйн нэгжүүд орно. Тайлант хугацаанд компанид холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ байхгүй байна.

8.1. Хяналтын харилцаа

Компаний 51,956 ширхэг хувьцааг нийт 35 хувьцаа эзэмшигч эзэмшдэг байна.

Хувьцаа эзэмшигч	Хувьцаа тоо хэмжээ /ширхэг/	Нийт хувьцаанд эзлэх хувь
"Ард секюритиз ҮЦК" ХХК	48,690	93.71%
Бусад хувьцаа эзэмшигчид	3,266	6.29%
Нийт	51,956	100%

9. Тайлагналын үеийн дараах үйл явдал

2022 оны 2 дугаар сарын 21-ний өдөр компанийн нийт хувьцааны 93.7 хувийг өөр этгээдэд шилжүүлэн өмчлөгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон байна. Компанийн өмчлөл шилжсэнтэй холбоотойгоор төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын багийг хараахан томилоогүй байна.